



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/75

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.6 дахь заалт, Хөдөлмөрийн Дотоод журмын 8.1, 8.2 дахь заалтуудыг тус тус ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн төвд шинээр ажилд орох эмч, эмнэлгийн мэргэжилтэн, захиргааны удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон үйлчилгээний ажилтнуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хүний нөөцийн алба /Л.Болормаа/-д, мөрдөж ажиллахыг Албадууд болон Дарь эх салбар нэгдсэн эмнэлэг, амбулаторийн эрхлэгч нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт хариуцсан ажилтанд даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн A/62 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



М.БОЛД

61

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн
1/75 дугаар тушаалын хавсралт



АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн Захиргаа, Дарь эх нэгдсэн эмнэлэг, Зөвлөх поликлиник, Салбар 1,2-р амбулаторид ажилд орох эмч, эмнэлгийн мэргэжилтэн, захиргааны удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон үйлчилгээний ажилтнуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Монгол улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.
- 1.3. Энэхүү журмын зорилго нь Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг чанаржуулахад оршино.

Хоёр. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

- 2.1. Хүний нөөцийн алба бусад албатай хамтран ажилтан сонгон шалгаруулах ажлыг тухай бүр зохион байгуулна.
- 2.2. Ажлын хэсгийн ахлагчаар Хүний нөөцийн албаны даргыг томилно.
- 2.3. Үндсэн ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, урт хугацааны цалингүй чөлөө авах, хүүхэд асрах тэтгэмжтэй чөлөөний хугацаанд гарсан сул орон тоо, мөн ажлын шаардлагаар шинээр бий болсон орон тоонд авч ажиллуулах иргэнд тавигдах ерөнхий шаардлагыг Эрүүл мэндийн төвийн даргаар батлуулсан албан тушаалын ажлын байрны тодорхойлолтоор тодорхойлно.
- 2.4. Сонгон шалгаруулалтад оролцогчдыг нийтлэг болон тусгай шалгуураар үнэлэн сонгоно. Нийтлэг шалгуурт тухайн шалгаруулалтад оролцогчийн ерөнхий соёл, зан харилцааны чадварыг үнэлж, тусгай шалгуурт мэргэжлийн ур чадвар, туршлагыг үнэлнэ.

- 2.5. Тухайн ажлын байранд тавигдах шалгуурыг Хүний нөөцийн албанаас ажлын байрны зард тавигдах шалгуурыг ил тод байдлаар Эрүүл мэндийн төвийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээллийг хүргэнэ.
- 2.6. Эмнэлгийн мэргэжилтнийг сонгон шалгаруулахдаа Хүний нөөцийн албанаас эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээгээр, Халдварын сэргийлэлт хяналтын багаас Халдварын сэргийлэлтийн мэдлэг шалгах шалгалт авна.
- 2.7. Ярилцлагыг Хүний нөөцийн албаны дарга тухайн сонгон шалгаруулж буй ажилтан хамаарах алба, нэгжийн дарга хамтран явуулна.

Гурав. Сонгон шалгаруулалтанд оролцогчийн бүрдүүлэх материал

- 3.1. Сонгон шалгаруулалтанд оролцогчид дараахь материалыг бүрдүүлнэ.

Үүнд:

- 3.1.1. Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 3.1.2. Төрийн албан хаагчийн анкет
- 3.1.3. Боловсролын гэрчилгээ, диплом, үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- 3.1.4. Мэргэжлийн үнэмлэх, лиценз, сертификат, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- 3.1.5. Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авах

- 4.1. Хүний нөөцийн алба сонгон шалгаруулалтанд оролцогчдоос шаардагдах материалыг хүлээн авч тухайн албан тушаалд ажиллах боломжтой эсэхийг судалсны дараа Эрүүл мэндийн төвийн даргад материалыг танилцуулна. Эрүүл мэндийн төвийн дарга туршилтаар ажиллуулах зөвшөөрлийг өгсний дараа харъяалах ажиллах нэгж рүү 3 хоногийн хугацаагаар Туршин ажиллуулах хуудсыг харъяалах нэгжийн дарга руу Хүний нөөцийн алба илгээнэ.
- 4.2. Туршин ажиллуулах 3 хоногийн хугацаа дууссаны дараа харъяалах нэгжийн дарга ажиллуулах боломжтой, боломжгүй эсэхийг Туршин ажиллуулсан хуудас дээр тэмдэглэл хийж гарын үсэг, тамгаар баталгаажуулж Хүний нөөцийн албанд ирүүлнэ.

Тав. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа

Сонгон шалгаруулалтыг дараахь үе шаттай явуулна. Үүнд:

- 5.1. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах бүртгэлийн хугацаа дуусахад ажлын хэсэг ирсэн материалуудтай нэг бүрчлэн танилцана
- 5.2. Эмнэлгийн мэргэжилтнээс энэ журмын 2 дахь хэсэгт заасан шалгалт авна
- 5.3. Ярилцлага хийх
- 5.4. Сонгон шалгаруулалтын дүн буюу туршин ажиллуулсан харъяа нэгжийн даргын шийдвэрийг Эрүүл мэндийн төвийн даргад танилцуулна.
- 5.5. Сонгогдсон ажилтныг томилсон Эрүүл мэндийн төвийн даргын гаргасан тушаалыг тухайн иргэнд танилцуулж, чиглүүлэх, дадлагажуулах сургалтыг Хүний нөөцийн алба зохион байгуулна.
- 5.6. Шинэ ажилтныг Хүний нөөцийн ажилтан харъяалах алба, амбулатори, салбар нэгдсэн эмнэлгийн даргад танилцуулсны дараа тухайн нэгжийн дарга нэгжийн хамт олонд танилцуулна.

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбогдох бичиг баримтыг дараа оны эхний улиралд байгууллагын архивт шилжүүлнэ.

